



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Манхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/008/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2026 он	Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Аудитор: Ц.Аззаяа Утас: 99125777 Цахим хаяг: azzaya@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.03.25 № 273

танай _____ -ны № _____ -т

МАНХАН СУМЫН ЗАСАГ ДАРГА
П.МЯГМАРСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Манхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Манхан сум нь 2025 онд малын тоо толгойгоор 249.6 мянган мал тоолуулсан нь Ховд аймгийн нийт 3.1 сая малын 7.3 хувийг эзэлж байна. Харин хүн амын өсөлт шилжилт хөдөлгөөнөөр урьдчилсан байдлаар 4154 хүн амтай байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх 6 хөтөлбөрийн 66 арга хэмжээний зардалд 3,144.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 2,899.9 сая төгрөгийг зарцуулснаас 2,510.1 сая төгрөгийг урсгал зардалд, 389.8 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн шилжих болон шинээр эхлэх 29 хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээнд тус тус зарцуулсан байна.

8426950678

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 бодлого зорилтын хүрээнд 66 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 85.0 хувийн гүйцэтгэлтэйгээр аймгийн Засаг даргаар үйл ажиллагаагаа дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	754,869.95	815,498.89
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	374,821.96	446,376.96
3	1.1.3 АВЛАГА	257,772.56	268,722.81
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	87,275.42	89,829.12
5	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	35,000	10,570
6	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,004,050.48	8,125,778.78
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,004,050.48	8,125,778.78
8	1.2.2.02 Биет хөрөнгө	5,911,528.68	7,905,825.38
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	92,521.8	219,953.4
10	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	6,758,920.43	8,941,277.67
11	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	29,023.10	60,202.3
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	29,023.10	60,202.3
13	2.1.1.03 Өглөг	29,023.10	60,202.3
14	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,729,897.33	8,881,075.36
15	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	6,729,897.33	8,881,075.36
16	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	974,241.35	974,241.35
17	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	4,766,988.34	6,918,166.38
18	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	988,667.63	988,667.63
19	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	6,758,920.43	8,941,277.67

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	6,254,635.15	8,287,609.1
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	784,877.87	766,950.56
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар	651,746.76	599,918.74
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	689,289.37	658,705.64
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-37,542.62	-58,786.9
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	88,415.94	108,414.66
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	44,715.17	58,617.16
8	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,144,276.1	7,520,658.50
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	4,202,354.72
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,325,481.18	0.0
11	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,545,506.92	6,136,126.53

12	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	5,545,506.92	6,136,126.53
13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,272,461.32	3,489,538.16
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	979,328.63	1,145,786.11
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	119,264.07	140,274.22
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	768,867.11	849,221.91
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	800,806.79	541,936.36
18	1.1.2.01.1.05 Нормативт зардал	531.6	285
19	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	9,310.3	12,740.85
20	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	8,738	10,565.1
21	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,733.65	35,152.45
22	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	555,881.18	753,576.17
23	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,273,045.60	2,646,588.38
24	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	709,128.23	2,151,482.52
25	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.0	304.49
26	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	0.0	-304.49
27	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	709,128.23	2,151,178.04

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	5,307,034.03	5,692,228.45
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	784,877.87	766,950.56
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	651,746.76	599,918.74
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-37,542.62	-58,786.9
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	88,415.94	108,414.66
6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	44,715.17	58,617.16
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,841.1	18,199.8
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	23,186.43	23,356.06
9	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	14,687.64	17,061.3
10	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	167,999.04	4,925,277.89
11	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	167,999.04	227,703.6
12	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	4,272,443.10

13	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	425,131.2
14	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,354,157.12	0.0
15	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,345,927.22	5,025,461.0
16	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	4,345,927.22	5,025,461.0
17	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,054,412.78	2,335,572.49
18	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	964,598.39	1,133,101.76
19	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	120,949.64	138,330.69
20	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	774,840.95	853,070.75
21	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	30,502.55	24,820.3
22	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	703.7	0.0
23	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	11,068.9	13,304.35
24	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	8,738	10,565.1
25	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,661.98	45,331.37
26	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	94,348.68	117,048.17
27	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,707.28	62,908.2
28	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	961,106.81	666,767.43
29	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	733,448.42	545,062.44
30	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	733,448.42	545,062.44
31	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	733,448.42	545,062.44
32	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-733,448.42	-545,062.44
33	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	50,150	50,150
34	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-50,150	-50,150
35	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	177,508.39	71,554.99
36	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	197,313.57	374,821.96
37	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	374,821.96	446,376.96

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,025,347.9	6,025,347.9
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,170.04	-1,170.04
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,024,177.86	6,024,177.86
4	1.1.1.1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-3,408.76	-3,408.76
5	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	709,128.23	709,128.23
6	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,729,897.33	6,729,897.33
7	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,729,897.33	6,729,897.33
8	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,729,897.33	6,729,897.33
9	1.7 Тайлант үеийн үр дүн	2,151,178.04	2,151,178.04
10	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	8,881,075.36	8,881,075.36

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,144,276.7	3,009,240.96
2	3.1.01.1.1 Татварын орлого	702,899.6	766,950.56
3	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	541,185.7	599,918.74
4	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	599,972.6	658,705.64
5	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-58,786.9	-58,786.9
6	3.1.01.1.1.1.2.01 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-58,786.9	-58,786.9
7	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	106,030	108,414.66
8	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	55,683.9	58,617.16
9	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	11,520	18,199.8
10	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	26,183.9	23,356.06
11	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	17,980	17,061.3
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	2,201,084.9	2,242,290.4
13	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	211,646.5	227,703.6
14	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	1,564,307.2	1,589,455.6
15	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	1,564,307.2	1,589,455.6
16	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	425,131.2	425,131.2
17	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,144,276.7	2,980,986.12
18	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	2,360,889.4	2,385,773.68
19	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,351,334.8	2,322,865.48
20	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,145,041.4	1,133,101.76

21	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	143,138.5	138,330.69
22	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	861,958.4	853,070.75
23	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	31,071.4	23,753.3
24	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	933.2	0.0
25	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	16,821.2	13,304.35
26	3.1.01.2.1.1.7 Томилот, зочны зардал	12,206.6	10,565.1
27	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,377.8	43,463.36
28	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	90,786.3	107,276.17
29	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,554.6	62,908.2
30	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	669,345.8	545,062.44
31	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	114,041.5	50,150
32	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-2,357,206.8	-28,254.84
33	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	374,821.96
34	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	446,376.96

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	56,007.1
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	56,007.1
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	56,007.1
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	56,007.1
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	56,007.1
350013	1.1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,100.7
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	472.3
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	43,434.1
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,707.0
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	12,707.0
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,707.0
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	1,067.0
210401	1.1.1.2.1.1.4.1 Бичиг хэрэг	875.0
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	192.0
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,868.0

210801	1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,868.0
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	9,772.0
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	9,772.0
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	43,300.1
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-43,300.1
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-43,300.1

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 44,400.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 8,800.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

Орон нутгийн хөгжлийн сангийн тайланд:

- ОНХС-гийн өр төлбөр 8,800.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Аудитаар залруулагдаагүй 35,600.0 мянган төгрөгийн алдаа илэрсний материаллаг алдааны зөрчил нь тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 69,031.4 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 35,600.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 35,600.0 мянган төгрөгийн 5 заалт бүхий зөвлөмж бичлээ.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1 Зөвлөмж

3.1.1 ОНХС-тай холбоотой асуудал

Илрүүлэлт: Гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд хугацаа хэтрүүлсэн бол алданги тооцох заалт оруулаагүйн улмаас хугацаа хэтрүүлсэн 7 иргэн, ААН-д алданги тооцож төлөх төлбөрөөс суутгал хийх боломжийг алдсан байгаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 11.1. “Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд алданги тооцох тухай заалт оруулж хугацаандаа хүлээлгэн өгөөгүй тохиолдолд алданги суутган тооцож хэвших.

3.1.2 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Баталгаа гаргаж ирүүлээгүй байхад гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд төлбөрийн харьцааг 70/30 хувиар хийж урьдчилгаа төлбөр олгосон. Гүйцэтгэлээр санхүүжилт олгоогүй байгаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 43.1. “Тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу баталгаа гаргасан бол ажлын бэлтгэл хангахад зориулан гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр төлнө”, 43.3. “Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 43 дугаар зүйлийг мөрдөн ажиллах, тендерийн баталгаа гаргаж ирүүлээгүй тохиолдолд урьдчилгаа санхүүжилт олгохгүй байх.

3.1.3 ОНХС-тай холбоотой асуудал

Илрүүлэлт: Иргэдийн санал авч эрэмблэгдээгүй Төрийн үйлчилгээний авто машины засвар үйлчилгээ гэсэн зардал баталж зарцуулсан нь ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.7.5. “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”, 4.7.6. “Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал”, гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд иргэдийн санал авч эрэмблэгдсэн төсөл арга хэмжээнд баталж санхүүжүүлэх.

3.1.4 Орлогын төлөвлөгөөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Газрын төлбөрийн орлого 2,827.8 мянга, Ан амьтан агнах зөвшөөрлийн хураамж 2,429.0 мянга, хөрөнгийн орлого 11,704.7, шууд бус орлогыг 13,980.7 мянган төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 6.2.2. “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”, 6.2.3. “урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх”, 41.2.1. “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”; гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын орлогыг нэр төрлөөр нь бодитой төлөвлөж биелэлтийг хангуулах.

3.1.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Спортын аварга дэд хөтөлбөрөөс тэтгэмж урамшуулал олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3. “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, 4.7.6. “Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал”, гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллан төсвийг зориулалт бусаар үрэлгэн зарцуулахыг таслан зогсоож, дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын

төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
ОНХС	Өр төлбөрийг санхүүгийн тайланд дутуу илэрхийлсэн	1	8,800.0	1	8,800.0			1	8,800.0				
ДҮН		1	8,800.0	1	8,800.0			1	8,800.0		0	0	0

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хуульд	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
ОНХС	Гэрээнд хугацаа хэтрүүлсэн бол алданги тооцох заалт оруулаагүй	1						1			
	Төлбөрийн харьцааг 70/30 хувиар хийж урьдчилгаа төлбөр олгосон. Гүйцэтгэлээр санхүүжилт олгоогүй	1						1			
	Иргэдийн санал авч эрэмблэгдээгүй Төрийн үйлчилгээний авто машины засвар үйлчилгээ гэсэн зардал баталж зарцуулсан	1	33,000.0						1	33,000.0	
Орлогын төлөвлөгөө	Газрын төлбөрийн орлого 2,827.8 мянга, Ан амьтан агнах зөвшөөрлийн хураамж 2,429.0 мянга, хөрөнгийн орлого 11,704.7, шууд бус орлогыг 13,980.7 мянган төгрөгөөр тус тус тасарсан.	1						1			
Нийт дүн		4	33,000.0			0	0	4	33,000.0	0	0

4.3 Санхүүгийн тайлангийн аудитын нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ОНХС-ын Спортын аварга дэд хөтөлбөрөөс тэтгэмж урамшуулал олгосон.	1	2,600.0					1	2,600.0	-	-	-	-
Дүн	1	2,600.0	-	-	-	-	1	2,600.0	-	-	-	-

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			